



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2024 оны 09 дүгээр сарын 23
№36 (1332)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ГАРЧИГ
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

596.	Органик бүтээгдэхүүний тухай /Шинэчилсэн найруулга/	3495
597.	Органик хүнсний тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	3528
598.	Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	3529
599.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай	3531
600.	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай	3533
601.	Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	3534
602.	Хүнсний тухай хуульд өөрчлөлт оруюулах тухай	3536

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН
ЦЭЦИЙН ТОГТООЛ**

603.	Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Авлигын эсрэг хуулийн холбогдох зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай	Дугаар 01	3537
------	---	-----------	------

905.	<p>Պատմության համալսարանի Բնագրաբանության և Գեոգրաֆիայի ինստիտուտի հրատարակած համալսարանական դասագրքերի և դասականների հավաքածուների համալրումը:</p>	Պատմություն	ՀՀԳԴ
904.	<p>Ստեփանյան Մ. և Ստեփանյան Լ. Սև Սև Սև</p>		ՀՀԳԹ
903.	<p>Ստեփանյան Լ. Սև Սև Սև:</p>		ՀՀԳԹ
900.	<p>Ստեփանյան Լ. Սև Սև Սև:</p>		ՀՀԳԴ
ՀԹԳ.	<p>Ստեփանյան Լ. Սև Սև Սև:</p>		ՀՀԳԹ
ՀԹԸ.	<p>Ստեփանյան Լ. Սև Սև Սև:</p>		ՀՀԳԹ
ՀԹԷ.	<p>Ստեփանյան Լ. Սև Սև Սև:</p>		ՀՀԳԴ
ՀԹԶ.	<p>Ստեփանյան Լ. Սև Սև Սև:</p>		ՀՀԳԹ

Ստեփանյան Մ. և Ստեփանյան Լ. Սև Սև Սև



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 01 дүгээр
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

ОРГАНИК БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх, боловсруулах, баталгаажуулах, бүртгэх, органик болохыг илэрхийлсэн тэмдэг хэрэглэх, сурталчлах, худалдаалах, органик үйлдвэрлэл эрхлэгчид төрөөс дэмжлэг үзүүлэх, урамшуулал олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Органик бүтээгдэхүүний хууль тогтоомж

2.1.Органик бүтээгдэхүүний хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Хүнсний тухай хууль², Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль³, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль⁴, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль⁵, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль⁶, Байгаль орчныг хамгаалах тухай хууль⁷, Ургамал хамгааллын тухай хууль⁸, Тариалангийн тухай хууль⁹, Байгалийн ургамлын тухай хууль¹⁰, Ойн тухай хууль¹¹, Зар сурталчилгааны

¹ Монгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1992 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

² Хүнсний тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2013 оны 02 дугаарт нийтлэгдсэн.

³ Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2013 оны 02 дугаарт нийтлэгдсэн.

⁴ Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2018 оны 02 дугаарт нийтлэгдсэн.

⁵ Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2018 оны 10 дугаарт нийтлэгдсэн.

⁶ Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2002 оны 46 дугаарт нийтлэгдсэн.

⁷ Байгаль орчныг хамгаалах тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1995 оны 5-6 дугаарт нийтлэгдсэн.

⁸ Ургамал хамгааллын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2007 оны 44 дугаарт нийтлэгдсэн.

⁹ Тариалангийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2016 оны 08 дугаарт нийтлэгдсэн.

¹⁰ Байгалийн ургамлын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1995 оны 5-6 дугаарт нийтлэгдсэн.

¹¹ Ойн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2012 оны 22 дугаарт нийтлэгдсэн.



тухай хууль¹², Зөрчлийн тухай хууль¹³, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь хөдөө аж ахуйн болон байгалийн гаралтай органик хүнс, хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүн, мал, амьтан, тэжээл, бордоо, таримлын үр, суулгацыг үржүүлэх, үйлдвэрлэх, бэлтгэх, боловсруулах, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, тээвэрлэх, хадгалах, савлах, шошголох, худалдаалах, экспортлох, импортлох үйл ажиллагаанд үйлчилнэ.

3.2.Энэ хуулийн 3.1-д заасан үйл ажиллагаа шилжилтийн үеийн органик үйлдвэрлэлийн бүх үе шатанд хамаарна.

3.3.Амьтны тухай хуулийн¹⁴ 4.1.7-д заасан агнуурын амьтны түүхий эдээр органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх ажиллагааг энэ хуулиар зохицуулахгүй.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“органик үйлдвэрлэл” гэж шилжилтийн үеийн болон органик үйлдвэрлэлийн бүх үе шатанд нөөцийг зохистой ашиглах, экосистемийн тэнцвэр, биологийн олон янз байдлыг хадгалахад чиглэсэн уламжлалт арга барил, биологи ба механик арга, технологийг хослуулан эрхлэхийг;

4.1.2.“органик бүтээгдэхүүн” гэж зохиомол аргаар нийлэгжүүлсэн нэмэлт бодис, эрдэс бордоо, пестицид, антибиотик, есөлтийн даавар, хувиргасан амьд организм, цацраг туяа хэрэглээгүй, энэ хуулийн 4.1.1-д заасан үйлдвэрлэлийн үр дүнг;

4.1.3.“органик үйлдвэрлэл эрхлэгч” гэж энэ хуулийн 4.1.1-д заасан үйлдвэрлэл эрхэлж байгаа хүн, хуулийн этгээдийг;

¹² Зар сурталчилгааны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 23 дугаарт нийтлэгдсэн.

¹³ Зөрчлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

¹⁴ Амьтны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

4.1.4. “органик болохыг илэрхийлсэн гэрчлэх тэмдэг” гэж эрх бүхий баталгаажуулалтын байгууллагаар баталгаажсан, органик бүтээгдэхүүний бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдсэн органик болон шилжилтийн үеийн түүхий эд, бүтээгдэхүүнийг гэрчилж, шошгод байршуулсан тэмдгийг;

4.1.5. “урьдчилан сэргийлэх арга хэмжээ” гэж органик бүтээгдэхүүн нь органик бус бүтээгдэхүүнтэй холилдох, энэ хуулийн 7.4-т заасан органик үйлдвэрлэлд хэрэглэхийг зөвшөөрсөн бодисын жагсаалтад зааснаас өөр бодисоор бохирдох эрсдэлээс зайлсхийхийг;

4.1.6. “хамтын баталгаажуулалт” гэж үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүнийг органик үйлдвэрлэлийн шаардлагад нийцэж байгаа эсэхэд хэрэглэгчийн идэвхтэй оролцоо, харилцан итгэлцэлд тулгуурлан үйлдвэрлэгч, хэрэглэгч болон бусад оролцогчид хамтран баталгаажуулахыг;

4.1.7. “хувиргасан амьд организм” гэж Хувиргасан амьд организмын тухай хуулийн¹⁵ 3.1.2-т заасныг;

4.1.8. “шилжилтийн үе” гэж үйлдвэрлэл эрхлэгч энэ хуулийн 9.1-д заасан баталгаажуулалт хийх эрх бүхий этгээдтэй гэрээ байгуулснаас эхлэн органик үйлдвэрлэлд бүрэн шилжих хүртэл хугацааг;

4.1.9. “шошго” гэж органик бүтээгдэхүүний оноосон болон худалдааны нэр, органик үйлдвэрлэлийн талаар бичсэн, хэвлэсэн, зурсан, товойлгосон, сийлсэн аливаа үг, бичиглэл, мэдэгдэл, тэмдэг, дардас, зураг, тухайн бүтээгдэхүүнийг дагалдах баримт бичиг, хуудас, зүүлт, хавчуурга, бөгж, хүзүүвчийг.

5 дугаар зүйл. Органик үйлдвэрлэлд баримтлах зарчим

5.1. Органик үйлдвэрлэлд дараах зарчмыг баримтална:

5.1.1. хөрс, ус, агаар, ургамал, амьтан, хүн амын одоо ба ирээдүйд эрүүл, аюулгүй оршин тогтнох, тэдгээрийн дархлаа, дасан зохицох чадварыг дэмжих, нөхөн сэргээх;

5.1.2. экосистемийн тэнцвэрийг хадгалах, биологийн олон янз байдлыг дэмжих, уламжлалт соёл, ёс заншлыг хүндэтгэх, үйлдвэрлэлийн нөөцийн тогтвортой байдлыг хангах;

¹⁵ Хувиргасан амьд организмын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2007 оны 29 дугаарт нийтлэгдсэн.



5.1.3.зах зээлийн өрсөлдөөн, үйлдвэрлэлийн бүх үе шатанд шударга, энэрэнгүй ёсыг баримтлах, гадаад орцын хэрэглээг хязгаарлах, мэдлэгээ хуваалцах;

5.1.4.бүтээгдэхүүний органик болон байгалийн шинж байдлыг хадгалах, нөөцийг зүй зохистой ашиглахад чиглэсэн арга технологиор үйлдвэрлэл эрхлэх;

5.1.5.уламжлалт мэдлэгийг шинжлэх ухааны ололттой хослуулан органик үйлдвэрлэлийн үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэх, шинэ технологийг нэвтрүүлэхдээ урьдчилсан үнэлгээ хийх, эрсдэлийг бууруулах, ил тод, нээлттэй шийдвэр гаргах;

5.1.6.шилжилтийн үеийн болон органик үйлдвэрлэлийг сайн дурын үндсэн дээр эрхлэх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ОРГАНИК ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ЭРХ, ҮҮРЭГ, ХОРИГЛОХ ЗҮЙЛС

6 дугаар зүйл.Органик үйлдвэрлэл эрхлэгчид тавигдах шаардлага

6.1.Органик үйлдвэрлэл эрхлэгч дараах нийтлэг шаардлагыг хангана:

6.1.1.энэ хуульд заасан шаардлага, журмыг баримталж органик үйлдвэрлэлд шилжих;

6.1.2.органик үйлдвэрлэлд шилжихдээ энэ хуулийн 7.4-т зааснаас бусад бодисыг тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хэрэглэхийг зогсоох;

6.1.3.усны бохирдлоос сэргийлэх, цас, борооны усыг ашиглах, хаягдал багатай, эсхүл хаягдалгүй усны технологи ашиглах;

6.1.4.биотехникийн болон биологийн олон янз байдлын чанарыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх;

6.1.5.өөрийн болон хөрш зэргэлдээ, нийтийн эзэмшлийн газрын байгаль орчин, эд зүйлсийг хамгаалах.

6.2.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч органик үйлдвэрлэлд шилжихдээ холбогдох хууль тогтоомжид заасан хүнсний аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна.

6.3.Хуулиар хориглоогүй бол улсын тусгай хамгаалалттай газар нутаг болон орчны бүсэд органик үйлдвэрлэл эрхэлнэ.

6.4.Орцын 95 болон түүнээс дээш хувь нь органик найрлагатай бүтээгдэхүүнийг органикт тооцно.

7 дугаар зүйл.Органик үйлдвэрлэл эрхлэгчийн эрх, үүрэг

7.1.Органик үйлдвэрлэл эрхлэгч дараах эрх эдэлнэ:

7.1.1.энэ хуулийн 9.1-д заасан эрх бүхий байгууллагаар баталгаажсан, органик бүтээгдэхүүний бүртгэл, мэдээллийн сан /цаашид “мэдээллийн сан” гэх/-д бүртгэлтэй шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүний шошгод энэ хуулийн 13.2-т заасан гэрчлэх тэмдэг хэрэглэх;

7.1.2.энэ хуульд заасны дагуу органик үйлдвэрлэлийг органик бус үйлдвэрлэлтэй хавсран эрхлэх;

7.1.3.нийлүүлэгчээс түүхий эд, бүтээгдэхүүнийг худалдан авахдаа органик болохыг тодорхойлсон баталгаа шаардах;

7.1.4.органик үйлдвэрлэл эрхлэхэд үндэсний, эсхүл олон улсын стандартыг хэрэглэх;

7.1.5.баталгаажуулалтын байгууллагыг сонгох;

7.1.6.хамтын баталгаажуулалтын байгууллагын гишүүнээр элсэх хүсэлт гаргах.

7.2.Органик үйлдвэрлэл эрхлэгч дараах үүрэг хүлээнэ:

7.2.1.баталгаажуулалтын байгууллагатай байгуулсан энэ хуулийн 11.4.1-д заасан гэрээний хэрэгжилтийг ханган ажиллах;

7.2.2.шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүнийг энэ хуулийн 12.2-т заасан журмын дагуу мэдээллийн цахим санд бүртгүүлэх, мэдээллийн үнэн зөвийг хариуцах;

7.2.3.урьдчилан сэргийлэх арга хэмжээг багтаасан шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх төлөвлөгөөний төслийг боловсруулж, баталгаажуулалтын байгууллагаар батлуулан хэрэгжүүлэх, энэ хуулийн 7.1.1-д заасан мэдээллийн санд тайлан, мэдээг хүргүүлэх;



7.2.4. мал, амьтан, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөгүй, түүхий эд, бүтээгдэхүүний байгалийн шинж чанарыг хадгалах үйлдвэрлэлийн арга, технологи боловсруулж мөрдөх;

7.2.5. шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах;

7.2.6. органик үйлдвэрлэлийг бүхэлд нь, эсхүл тухайн төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхээ зогсоосон бол ажлын 10 өдөрт багтаан баталгаажуулалтын байгууллагад мэдэгдэх;

7.2.7. энэ хуулийн 11.4.1-д заасан гэрээнд тусгасан хугацаанд давтан баталгаажуулалтад хамрагдах;

7.2.8. энэ хуульд өөрөөр заагаагүй бол баталгаажуулалтын зардлыг хариуцах;

7.2.9. ойн дагалт баялаг болон байгалийн ургамал түүж ашиглахдаа Ойн тухай хууль, Байгалийн ургамлын тухай хуулийн холбогдох зүйл, заалтыг хэрэгжүүлэх;

7.2.10. сүүлийн гурван жилийн хугацаанд энэ хуулийн 7.4-т заасан жагсаалтад орсноос бусад бодисыг хэрэглээгүй, авто зам болон бохирдлын эх үүсвэр, эсхүл органик бус аж ахуйгаас 1 км-ээс багагүй зайтай талбайгаас ойн дагалт баялаг болон байгалийн ургамлыг түүх;

7.2.11. энэ хуулийн 7.1.2-т заасны дагуу органик үйлдвэрлэлийг органик бус үйлдвэрлэлтэй хавсран эрхлэхээс өмнө баталгаажуулалтын байгууллагад мэдэгдэх;

7.2.12. ойн дагалт баялаг болон байгалийн ургамлыг түүх ажлыг бусдаар гүйцэтгүүлэх бол холбогдох хууль тогтоомжийн талаарх мэдээлэл, зааварчилгаа өгч, тэмдэглэл хөтлөх.

7.3. Сум, дүүргийн байгаль орчны асуудал хариуцсан албан тушаалтан энэ хуулийн 7.2.10-т заасан талбайг тогтоож, тодорхойлолт олгоно.

7.4. Органик үйлдвэрлэлд хэрэглэх бодист тавигдах шаардлага, тэдгээрийг үнэлэх аргачлал болон жагсаалтыг хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

8 дугаар зүйл. Органик үйлдвэрлэлд хориглох зүйл



8.1.Органик үйлдвэрлэлд дараах зүйлийг хориглоно:

8.1.1.энэ хуулийн 7.4-т заасан жагсаалтад орсноос бусад бодис хэрэглэх;

8.1.2.органик бүтээгдэхүүнийг боловсруулах явцдаа цацрагийн боловсруулалт хийх;

8.1.3.айл өрх болон үйлдвэр, аж ахуйн газрын бохир, хот, суурины цэвэрлэх байгууламжийн лаг ашиглах;

8.1.4.эсээр үржүүлэх /клонинг/ аргаар гарган авсан мал, амьтан, тэдгээрийн үр төл ашиглах;

8.1.5.хувиргасан амьд организм, түүнээс гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн болон өсөлтийн даавар ашиглах;

8.1.6.хөрсгүй технологи /гидропоник/ ашиглах;

8.1.7.энэ хуулийн болон эрүүл ахуйн шаардлага хангаагүй, буруу шошготой хуурамч түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх, сурталчлах;

8.1.8.органик бүтээгдэхүүнтэй харьцах бүх төрлийн гадаргуу, сав, баглаа, боодолд нано бүтэцтэй материал ашиглах.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ
ОРГАНИК БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БАТАЛГААЖУУЛАЛТ,
БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САН, ШОШГО**

9 дүгээр зүйл.Баталгаажуулалтын байгууллага

9.1.Органик үйлдвэрлэлийн баталгаажуулалтыг доор дурдсан эрх бүхий байгууллага /цаашид “баталгаажуулалтын байгууллага” гэх/ гүйцэтгэнэ:

9.1.1.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу итгэмжлэгдсэн, эсхүл бүртгүүлсэн баталгаажуулалтын байгууллага;

9.1.2.хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад энэ хуульд заасны дагуу бүртгүүлсэн хамтын баталгаажуулалтын байгууллага.



9.2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хоёр болон олон талт олон улсын гэрээнд органик бүтээгдэхүүний баталгаажуулалтын дүнг харилцан хүлээн зөвшөөрөх асуудлыг тусгана.

9.3.Итгэмжлэлийн байгууллага энэ хуулийн 9.1.1-д заасан баталгаажуулалтын байгууллагын мэдээллийг, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 9.1.2-т заасан хамтын баталгаажуулалтын байгууллагын мэдээллийг органик бүтээгдэхүүний мэдээллийн санд оруулна.

9.4.Энэ хуулийн 9.1.2-т заасан хамтын баталгаажуулалтын байгууллагад тавигдах шаардлага, түүнийг байгуулах, бүртгүүлэх, баталгаажуулалт хийх журмыг хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

9.5.Баталгаажуулалтын байгууллага нь эрх бүхий байгууллагаас олгосон давхцалгүй бүртгэлийн дугаартай байна.

10 дугаар зүйл.Баталгаажуулалтын байгууллагын үүрэг

10.1.Баталгаажуулалтын байгууллага дараах үүрэг хүлээнэ:

10.1.1.органик үйлдвэрлэл эрхлэх, баталгаажуулах тухай гэрээг үйлдвэрлэл эрхлэгчтэй байгуулах, хэрэгжүүлэх, хянах;

10.1.2.энэ хуулийн 9.1.1-д заасан баталгаажуулалтын байгууллага баталгаажуулалтыг олон улсад мөрдөгддөг стандарт баримт бичгийн дагуу гүйцэтгэх;

10.1.3.хамтын баталгаажуулалтын байгууллага энэ хуулийн 9.4-т заасан журмын дагуу баталгаажуулалтыг гүйцэтгэх;

10.1.4.энэ хуулийн 12.2-т заасан журмын дагуу органик үйлдвэрлэлийн байршил, төрөл, мэдээллийн сангийн бүртгэл, мэдээлэл, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний дүгнэлтийг харгалзан шаардлагатай тохиолдолд шилжилтийн үеийн хугацааг тогтоох;

10.1.5.энэ хуулийн 12.2-т заасан журмын дагуу органик үйлдвэрлэл эрхлэх, баталгаажуулах тухай гэрээний хэрэгжилт, тохирлын үнэлгээний тайлан, баталгаажуулалтын гэрчилгээ, шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх төлөвлөгөө, шаардлагатай бусад мэдээлэл, баримт бичгийг мэдээллийн санд оруулах;



10.1.6.органик үйлдвэрлэл эрхлэгч энэ хуулийн 8.1-д заасныг зөрчиж үйлдвэрлэл явуулсан бол баталгаажуулалтыг хүчингүй болгож, энэ тухай мэдээллийн санд ажлын 10 өдөрт багтаан мэдэгдэх.

10.2.Энэ хуулийн 9.1.1-д заасан баталгаажуулалтын байгууллага шаардлагатай гэж үзвэл үйлдвэрлэл эрхлэгчийг бүлгээр нь баталгаажуулж болно.

10.3.Мэдээллийн санд бүртгэлгүй баталгаажуулалтын байгууллага шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүнийг баталгаажуулахыг хориглоно.

11 дүгээр зүйл.Органик бүтээгдэхүүнийг баталгаажуулах, бүртгэх

11.1.Үйлдвэрлэл эрхлэгч органик үйлдвэрлэлд шилжих тухай хүсэлтийг мэдээллийн санд илгээхдээ дараах шаардлагыг хангасан байна:

11.1.1.дотоод хяналтын хуудсыг бөглөх;

11.1.2.мэдээллийн санд хэрэглэгчээр бүртгүүлэх маягтыг бөглөх.

11.2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шаардлага хангасан үйлдвэрлэл эрхлэгчийг хэрэглэгчээр бүртгэж, мэдээллийн санд хандах эрх олгоно.

11.3.Үйлдвэрлэл эрхлэгч мэдээллийн санд бүртгэлтэй баталгаажуулалтын байгууллагаас сонгож, органик үйлдвэрлэлд шилжих тухай хүсэлт, холбогдох бусад мэдээллийг тухайн баталгаажуулалтын байгууллагад илгээнэ.

11.4.Баталгаажуулалтын байгууллага дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

11.4.1.үйлдвэрлэл эрхлэгчийн үйл ажиллагаанд урьдчилсан үнэлгээ хийж, хуульд заасан шаардлага хангасан гэж үзвэл органик үйлдвэрлэл эрхлэх, баталгаажуулах тухай гэрээг байгуулж, хэрэгжилтийг хангуулах;

11.4.2.шаардлага хангасан үйлдвэрлэл эрхлэгчид шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүнд баталгаажуулалтын гэрчилгээ олгож, холбогдох баримт бичгийн хамт мэдээллийн санд илгээх.

11.5.Мэдээллийн сангаас шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүн бүртгэгдсэн тухай мэдэгдэл ирснээр үйлдвэрлэл эрхлэгчид

бүтээгдэхүүний шошгод органик болохыг илэрхийлсэн гэрчлэх тэмдэг хэрэглэх эрх үүснэ.

11.6.Энэ хуулийн 11.4.2-т заасан баталгаажуулалтын гэрчилгээний загварыг хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

11.7.Органик үйлдвэрлэл эрхлэгч нь органик үйлдвэрлэлийн талаарх олон улсын стандартын дагуу баталгаажуулалт хийлгэсэн бол органик болохыг илэрхийлсэн гэрчлэх тэмдгийг хэрэглэж болно.

12 дугаар зүйл. Органик бүтээгдэхүүний бүртгэл, мэдээллийн сан

12.1.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталгаажсан шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэй холбогдох мэдээллийн цахим санг бүрдүүлж, тухай бүр шинэчлэн, нийтэд нээлттэй байлгана.

12.2.Мэдээллийн санд баталгаажсан шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүнийг бүртгүүлэх тухай журмыг хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.3.Гаалийн байгууллага улсын хилээр нэвтрүүлсэн органик бүтээгдэхүүнтэй холбоотой мэдээллийг мэдээллийн санд илгээнэ.

12.4.Мэдээллийн сангийн үйл ажиллагааг Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн¹⁶ 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт зааснаар мэдээллийн технологийн чиглэлээр мэргэшсэн, чадамжтай Засгийн газрын бус байгууллагад хариуцуулж болно.

13 дугаар зүйл. Органик бүтээгдэхүүний шошго

13.1.Энэ хуульд заасны дагуу баталгаажуулж, бүртгүүлсэн бүтээгдэхүүний шошгод органик болохыг илэрхийлсэн гэрчлэх тэмдэг тавина.

13.2.Органик болохыг илэрхийлсэн гэрчлэх тэмдэг шилжилтийн үед шар, органик үйлдвэрлэлд шилжсэнээс хойш ногоон өнгийн дэвсгэртэй байна.

13.3.Энэ хуулийн 13.8-д заасан аргачлалын дагуу бүтээгдэхүүний органик орц, найрлагыг тооцож шошгод тусгана.

¹⁶ Монгол Улсын Засгийн газрын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1993 оны 03 дугаарт нийтлэгдсэн.



13.4.Органик бүтээгдэхүүнийг сав, баглаа боодолгүй бөөнөөр нь худалдаалах тохиолдолд баталгаажуулалтын гэрчилгээг нийтэд ил харагдахуйц газар байршуулна.

13.5.Органик болохыг илэрхийлсэн гэрчлэх тэмдгийг хэрэглэхэд дараах үйлдлийг хориглоно:

13.5.1.органик бус бүтээгдэхүүнийг органик болохыг илэрхийлсэн гэрчлэх тэмдэгтэйгээр нийтийн хэрэгцээнд нийлүүлэх, зар сурталчилгаанд ашиглах;

13.5.2.шилжилтийн үед үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний шошгод ногоон өнгийн дэвсгэртэй гэрчлэх тэмдэг хэрэглэн нийтийн хэрэгцээнд нийлүүлэх, зар сурталчилгаанд ашиглах.

13.6.Бүтээгдэхүүний шошгод монгол болон гадаад хэлээр бичигдсэн “органик”, “байгалийн цэвэр”, “байгалийн гаралтай цэвэр”, “эко”, “ногоон”, “экологийн гаралтай”, “экологийн цэвэр”, “экологийн”, “био”, “биологийн”, “биологийн гаралтай”, “биологийн цэвэр” гэсэн үг болон эдгээртэй агуулгын хувьд дүйцэх үгийг хэрэглэх бол энэ хуулийг дагаж мөрдөнө.

13.7.Улсын бүртгэлийн байгууллага энэ хуулийн 13.6-д заасан үг болон эдгээртэй агуулгын хувьд дүйцэх үгийг хуулийн этгээдийн нэрээр баталгаажуулахгүй.

13.8.Органик бүтээгдэхүүний орц, найрлага тооцох аргачлалыг хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ОРГАНИК БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХУДАЛДАА, ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭГЧИД ҮЗҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ, УРАМШУУЛАЛ

14 дүгээр зүйл.Органик бүтээгдэхүүнийг худалдаалах

14.1.Дотоодын болон импортын баталгаажсан органик бүтээгдэхүүнийг мэдээллийн санд бүртгүүлсний дараа Монгол Улсын зах зээлд худалдаална.

14.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт худалдаалах импортын органик бүтээгдэхүүн нь холбогдох хуульд зааснаас гадна дараах шаардлага хангасан байна:

14.2.1.экспортлогч улсын эрх бүхий баталгаажуулалтын байгууллагаас олгосон органик болохыг тодорхойлсон хүчин төгөлдөр гэрчилгээтэй байх;

14.2.2.импортын органик хүнсийг жижиглэн савласан тохиолдолд шошго нь Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 12.8-д заасан болон холбогдох журам, стандартын шаардлагыг хангасан байх.

14.3.Бөөнөөр нийлүүлсэн органик бүтээгдэхүүний шошгын мэдээлэл жижиглэн савласан органик бүтээгдэхүүний шошгын мэдээлэлтэй ижил байх ба савласан он, сар, өдрийг шошгод ил харагдахуйц тусгана.

14.4.Импортлогч, экспортлогч нь органик бүтээгдэхүүнийг мэдээллийн санд бүртгүүлэх үүрэгтэй.

15 дугаар зүйл.Төрийн байгууллагын бүтэц, чиг үүрэг

15.1.Органик үйлдвэрлэлийн бодлого, эрх зүйн зохицуулалтыг төлөвлөх, удирдан зохион байгуулах, хэрэгжүүлэх чиг үүргийг улсын хэмжээнд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллага, сум, дүүрэгт хөдөө аж ахуйн нэгж хариуцан гүйцэтгэнэ.

15.2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага органик үйлдвэрлэлийн асуудлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

15.2.1.Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогод органик үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжих бодлогыг тусгах, салбар хоорондын уялдааг хангах, хэрэгжүүлэх;

15.2.2.энэ хуулийн 12.1-д заасан мэдээллийн санг байгуулах, шинэчлэх, шаардлагатай бусад мэдээллийн сантай холбох;

15.2.3.шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүн, органик үйлдвэрлэл эрхлэгчийг мэдээллийн санд бүртгэх үйл ажиллагааг удирдах, холбогдох мэдээллийг олон улсын байгууллагад хүргүүлэх;

15.2.4.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төвийн бүтэцэд органик үйлдвэрлэлийг хөгжүүлэх судалгааны нэгж байгуулах;



15.2.5.органик үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын болон бүс нутгийн байгууллагатай хамтран ажиллах, гишүүний татвар, хандивыг улсын төсвөөс төлөх;

15.2.6.органик салбарын Үндэсний зөвлөлийг байгуулах, ажиллах журмыг батлах.

15.3.Органик үйлдвэрлэлд тавигдах шаардлага, баримтлах журмыг хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

15.4.Энэ хуулийн 15.3-т заасан журамд дараах асуудлыг тусгана:

15.4.1.мал аж ахуйн органик үйлдвэрлэл эрхлэх;

15.4.2.тариалангийн органик үйлдвэрлэл эрхлэх;

15.4.3.органик хүнсийг боловсруулах үйлдвэрлэл эрхлэх;

15.4.4.зөгийн органик аж ахуй эрхлэх;

15.4.5.хоол үйлдвэрлэл, үйлчилгээг органик зарчимд нийцүүлэн эрхлэх;

15.4.6.хүнсний бус органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх;

15.4.7.органик бүтээгдэхүүнийг баталгаажуулах, бүртгэх, органик болохыг илэрхийлсэн гэрчлэх тэмдгийг шошгод байршуулах, нийтийн хэрэгцээнд нийлүүлэх;

15.4.8.органик бүтээгдэхүүнийг хадгалах, савлах, тээвэрлэх, экспортлох, импортлох.

15.5.Органик үйлдвэрлэлийг органик бус үйлдвэрлэлтэй хавсран эрхлэх асуудлыг энэ хуулийн 15.3-т заасан журамд тусгана.

15.6.Аймаг, нийслэлийн Засаг дарга органик үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжих талаар тухайн орон нутгийг хөгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөртөө тусгаж, хэрэгжилтийг зохион байгуулан, үр дүнг мэдээллийн санд оруулна.

15.7.Итгэмжлэлийн байгууллага нь органик бүтээгдэхүүний тохирлын үнэлгээний дүнг олон улс, бүс нутаг, гадаад улстай харилцан хүлээн зөвшөөрөх асуудлыг хариуцна.

**16 дугаар зүйл.Төрөөс органик үйлдвэрлэл эрхлэгчид
үзүүлэх дэмжлэг**

16.1.Органик үйлдвэрлэл эрхлэгчийн дараах үйл ажиллагаанд доор дурдсан мөнгөн дэмжлэг үзүүлнэ:

16.1.1.шилжилтийн үеийн баталгаажуулалтын зардал;

16.1.2.дотоодод үйлдвэрлэсэн, баталгаажсан, мэдээллийн санд бүртгэлтэй органик бордоог тариалангийн талбай, хүлэмждээ ашигласан тохиолдолд органик үйлдвэрлэл эрхлэгчийн бордоо худалдан авсан эхний гурван жилийн зардал.

16.2.Органик үйлдвэрлэл эрхлэгчид дараах мөнгөн бус дэмжлэг үзүүлнэ:

16.2.1.сургуулийн өмнөх болон бүх шатны боловсролын байгууллагын дэргэд органик туслах аж ахуйг хөгжүүлэх;

16.2.2.баталгаажсан, мэдээллийн санд бүртгэлтэй органик бүтээгдэхүүнийг экспортолсон тохиолдолд үйлдвэрлэл эрхлэгчийн хөрөнгө оруулалтад зориулан арилжааны банкнаас авсан зээлийн 50-аас доошгүй хувьд хүүгийн дэмжлэг үзүүлэх;

16.2.3.дэвшилтэт арга, технологи нэвтрүүлж нутагшуулан шинэ нэр төрлийн органик бүтээгдэхүүн үйлдвэрлэж нийтийн хэрэгцээнд нийлүүлсэн нь Технологи дамжуулах тухай хуульд¹⁷ заасны дагуу нотлогдсон тохиолдолд судалгаа, хөгжилд зарцуулсан зардлын 75 хүртэлх хувьтай тэнцэх дэмжлэгийг нэг удаа улсын төсвөөс олгох;

16.2.4.органик үйлдвэрлэл эрхлэгчид татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх;

16.2.5.органик бүтээгдэхүүнтэй холбогдох мэдээлэл, сургалт, сурталчилгааг улсын төсвөөс санхүүжүүлэх.

16.3.Органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортод төрөөс үзүүлэх дэмжлэг, урамшуулалтай холбогдох журмыг хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

16.4.Энэ хуулийн 16.2.1-д заасан дэмжлэг үзүүлэх асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцаж хэрэгжүүлнэ.

¹⁷ Технологи дамжуулах тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1998 оны 06 дугаарт нийтлэгдсэн.

ТАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

17 дугаар зүйл.Органик үйлдвэрлэл, органик бүтээгдэхүүнд тавих хяналт

17.1.Органик үйлдвэрлэл эрхлэгч органик бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуй, аюулгүй байдал болон зөрчлөөс үүсэн гарах үр дагаврыг бүрэн хариуцна.

17.2.Баталгаажуулалтын байгууллага органик бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн үйл явцад олон улсын норматив баримт бичиг болон энэ хуулийн 11.4.1-д заасан гэрээний дагуу хяналтыг хэрэгжүүлнэ.

17.3.Нийтийн хэрэгцээнд нийлүүлсэн органик бүтээгдэхүүний шошгод тавих төрийн хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хууль¹⁸ болон бусад холбогдох хуулиар зохицуулна.

18 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

18.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд¹⁹ заасан хариуцлага хүлээлгэнэ.

18.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль²⁰, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

19 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

19.1.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

¹⁸ Төрийн хяналт шалгалтын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2003 оны 02 дугаарт нийтлэгдсэн.

¹⁹ Төрийн албаны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

²⁰ Эрүүгийн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2015 оны 07 дугаарт нийтлэгдсэн.



0.6.6. Өвчлөхтэй гэрээний үндсэн дээр үйлдвэрлэлд оролцох үйлдвэр:

0.6.7. Өвчлөхтэй гэрээний үндсэн дээр үйлдвэрлэлд оролцох үйлдвэр:

0.6.8. Өвчлөхтэй гэрээний үндсэн дээр үйлдвэрлэлд оролцох үйлдвэр:

0.6.9. Өвчлөхтэй гэрээний үндсэн дээр үйлдвэрлэлд оролцох үйлдвэр:

0.6.10. Өвчлөхтэй гэрээний үндсэн дээр үйлдвэрлэлд оролцох үйлдвэр:

0.6.11. Өвчлөхтэй гэрээний үндсэн дээр үйлдвэрлэлд оролцох үйлдвэр:

0.6.12. Өвчлөхтэй гэрээний үндсэн дээр үйлдвэрлэлд оролцох үйлдвэр:

0.6.13. Өвчлөхтэй гэрээний үндсэн дээр үйлдвэрлэлд оролцох үйлдвэр:

0.6.14. Өвчлөхтэй гэрээний үндсэн дээр үйлдвэрлэлд оролцох үйлдвэр:

0.6.15. Өвчлөхтэй гэрээний үндсэн дээр үйлдвэрлэлд оролцох үйлдвэр:

0.6.16. Өвчлөхтэй гэрээний үндсэн дээр үйлдвэрлэлд оролцох үйлдвэр:

0.6.17. Өвчлөхтэй гэрээний үндсэн дээр үйлдвэрлэлд оролцох үйлдвэр:

0.6.18. Өвчлөхтэй гэрээний үндсэн дээр үйлдвэрлэлд оролцох үйлдвэр:

6.6.6. Өдөр тутамд үйлдвэр, ажлаа хөгжүүлж, өндөр амжилттай ажилладаг байхыг хангах үүрэг.

Бүтээгч:

6.6.7. Өдөр тутамд үйлдвэр, ажлаа хөгжүүлж, өндөр амжилттай ажилладаг байхыг хангах үүрэг.

6.6.8. Өдөр тутамд үйлдвэр, ажлаа хөгжүүлж, өндөр амжилттай ажилладаг байхыг хангах үүрэг.

Өдөр тутамд үйлдвэр, ажлаа хөгжүүлж, өндөр амжилттай ажилладаг байхыг хангах үүрэг.

6.6.9. Өдөр тутамд үйлдвэр, ажлаа хөгжүүлж, өндөр амжилттай ажилладаг байхыг хангах үүрэг.

Бүтээгч: ..

Тэмдэгтэй үгс

• Өдөр тутамд үйлдвэр, ажлаа хөгжүүлж, өндөр амжилттай ажилладаг байхыг хангах үүрэг.

• Өдөр тутамд үйлдвэр, ажлаа хөгжүүлж, өндөр амжилттай ажилладаг байхыг хангах үүрэг.

9. Өдөр тутамд үйлдвэр, ажлаа хөгжүүлж, өндөр амжилттай ажилладаг байхыг хангах үүрэг.

10. Өдөр тутамд үйлдвэр, ажлаа хөгжүүлж, өндөр амжилттай ажилладаг байхыг хангах үүрэг.

11. Өдөр тутамд үйлдвэр, ажлаа хөгжүүлж, өндөр амжилттай ажилладаг байхыг хангах үүрэг.

12. Өдөр тутамд үйлдвэр, ажлаа хөгжүүлж, өндөр амжилттай ажилладаг байхыг хангах үүрэг.

13. Өдөр тутамд үйлдвэр, ажлаа хөгжүүлж, өндөр амжилттай ажилладаг байхыг хангах үүрэг.

14. Өдөр тутамд үйлдвэр, ажлаа хөгжүүлж, өндөр амжилттай ажилладаг байхыг хангах үүрэг.

15. Өдөр тутамд үйлдвэр, ажлаа хөгжүүлж, өндөр амжилттай ажилладаг байхыг хангах үүрэг.

16. Өдөр тутамд үйлдвэр, ажлаа хөгжүүлж, өндөр амжилттай ажилладаг байхыг хангах үүрэг.

17. Өдөр тутамд үйлдвэр, ажлаа хөгжүүлж, өндөр амжилттай ажилладаг байхыг хангах үүрэг.

Бүтээгч: ..



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 01 дүгээр
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
ХОТ

ОРГАНИК ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2016 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр баталсан
Органик хүнсний тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Органик бүтээгдэхүүний тухай хууль
/Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж
мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Индрига Голд Ог Нөлл

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠭᠣᠯ

ᠬᠤᠭᠣᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ
ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠭᠣᠯ

ᠬᠤᠭᠣᠯ ᠬᠤᠭᠣᠯ ᠬᠤᠭᠣᠯ ᠬᠤᠭᠣᠯ ᠬᠤᠭᠣᠯ
ᠬᠤᠭᠣᠯ ᠬᠤᠭᠣᠯ ᠬᠤᠭᠣᠯ ᠬᠤᠭᠣᠯ ᠬᠤᠭᠣᠯ

ᠬᠤᠭᠣᠯ ᠬᠤᠭᠣᠯ ᠬᠤᠭᠣᠯ ᠬᠤᠭᠣᠯ ᠬᠤᠭᠣᠯ
ᠬᠤᠭᠣᠯ ᠬᠤᠭᠣᠯ ᠬᠤᠭᠣᠯ ᠬᠤᠭᠣᠯ ᠬᠤᠭᠣᠯ

ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠭᠣᠯ ᠬᠤᠭᠣᠯ

ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠭᠣᠯ ᠬᠤᠭᠣᠯ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 01 дүгээр
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 39 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 39.1.4.5 дахь дэд заалт нэмсүгэй:

“39.1.4.5.Монгол Улсад үйлдвэрлэсэн органик бордоо хэрэглэх;”

2 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.4.5 дахь дэд заалтын дугаарыг “39.1.4.6” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Органик бүтээгдэхүүний тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР



Мэдээлэл

Хуульчилсан үндэс

2024 оны 36 дугаар тогтоол

Хуульчилсан үндэс / Хуульчилсан үндэс / Хуульчилсан үндэс /

Хуульчилсан үндэс... Хуульчилсан үндэс / Хуульчилсан үндэс / Хуульчилсан үндэс /

«Хуульчилсан үндэс / Хуульчилсан үндэс / Хуульчилсан үндэс /»

Хуульчилсан үндэс... Хуульчилсан үндэс / Хуульчилсан үндэс / Хуульчилсан үндэс /

Хуульчилсан үндэс... Хуульчилсан үндэс / Хуульчилсан үндэс / Хуульчилсан үндэс /

Хуульчилсан үндэс / Хуульчилсан үндэс /



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 01 дүгээр
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 22.5.20 дахь заалт нэмсүгэй:

“22.5.20.Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 4.1.2-т заасан органик бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн аж ахуйн нэгжийн зөвхөн тухайн бүтээгдэхүүнээс олсон орлогод ногдох албан татварыг орлого олж эхэлсэн эхний таван жилд 100 хувиар, дараагийн таван жилд 50 хувиар хөнгөлнө.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Органик бүтээгдэхүүний тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР



Мэдээлэл

Мэдээлэл

2024 оны 11 сарын 15 - 16 өдөр

Мэдээлэл
Мэдээлэл
Мэдээлэл

Мэдээлэл... Мэдээлэл... Мэдээлэл...
Мэдээлэл... Мэдээлэл... Мэдээлэл...
Мэдээлэл... Мэдээлэл... Мэдээлэл...

Мэдээлэл... Мэдээлэл... Мэдээлэл...
Мэдээлэл... Мэдээлэл... Мэдээлэл...
Мэдээлэл... Мэдээлэл... Мэдээлэл...

Мэдээлэл... Мэдээлэл... Мэдээлэл...
Мэдээлэл... Мэдээлэл... Мэдээлэл...
Мэдээлэл... Мэдээлэл... Мэдээлэл...

Мэдээлэл
Мэдээлэл

Мэдээлэл



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 01 дүгээр
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 7.1.3 дахь заалтын “орон нутгийн” гэсний өмнө “органик,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Органик бүтээгдэхүүний тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Мөрдөгч Фолд_оа Нөвд

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ

ᠶᠡᠨᠨᠢᠭᠡᠨ ᠬᠡᠭᠡᠨ ᠬᠡᠭᠡᠨ ᠬᠡᠭᠡᠨ
ᠬᠡᠭᠡᠨ ᠬᠡᠭᠡᠨ ᠬᠡᠭᠡᠨ ᠬᠡᠭᠡᠨ
ᠬᠡᠭᠡᠨ ᠬᠡᠭᠡᠨ ᠬᠡᠭᠡᠨ ᠬᠡᠭᠡᠨ

ᠶᠡᠨᠨᠢᠭᠡᠨ ᠬᠡᠭᠡᠨ ᠬᠡᠭᠡᠨ ᠬᠡᠭᠡᠨ
ᠬᠡᠭᠡᠨ ᠬᠡᠭᠡᠨ ᠬᠡᠭᠡᠨ ᠬᠡᠭᠡᠨ
ᠬᠡᠭᠡᠨ ᠬᠡᠭᠡᠨ ᠬᠡᠭᠡᠨ ᠬᠡᠭᠡᠨ

ᠶᠡᠨᠨᠢᠭᠡᠨ ᠬᠡᠭᠡᠨ ᠬᠡᠭᠡᠨ ᠬᠡᠭᠡᠨ
ᠬᠡᠭᠡᠨ ᠬᠡᠭᠡᠨ ᠬᠡᠭᠡᠨ ᠬᠡᠭᠡᠨ
ᠬᠡᠭᠡᠨ ᠬᠡᠭᠡᠨ ᠬᠡᠭᠡᠨ ᠬᠡᠭᠡᠨ

ᠶᠡᠨᠨᠢᠭᠡᠨ ᠬᠡᠭᠡᠨ ᠬᠡᠭᠡᠨ
ᠬᠡᠭᠡᠨ ᠬᠡᠭᠡᠨ ᠬᠡᠭᠡᠨ ᠬᠡᠭᠡᠨ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 01 дүгээр
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 6.16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “эрхлэгч” гэсний дараа “, импортлогч, экспортлогч” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 6.16 дугаар зүйлийн 3.1 дэх заалтын “импортын органик хүнс” гэснийг “органик бүтээгдэхүүн” гэж, мөн зүйлийн 4.1 дэх заалтын “хүнсийг” гэснийг “бүтээгдэхүүнийг” гэж, 4.2 дахь заалтын “холбогдох төрийн байгууллагад” гэснийг “мэдээллийн санд” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 6.16 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.2 дахь заалтын “тэмдэглэгээ,” гэснийг хассугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Органик бүтээгдэхүүний тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 01 дүгээр
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хүнсний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтын “тэжээл болон органик хүнсний” гэснийг “тэжээлийн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Органик бүтээгдэхүүний тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Монгол Улсын
Их Хурлын дарга

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ
ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ

ᠬᠡᠭᠢᠨ ᠲᠤᠭᠤᠯᠠᠭ ᠲᠤᠭᠤᠯᠠᠭ
ᠲᠤᠭᠤᠯᠠᠭ ᠲᠤᠭᠤᠯᠠᠭ ᠲᠤᠭᠤᠯᠠᠭ
ᠲᠤᠭᠤᠯᠠᠭ ᠲᠤᠭᠤᠯᠠᠭ ᠲᠤᠭᠤᠯᠠᠭ
ᠲᠤᠭᠤᠯᠠᠭ ᠲᠤᠭᠤᠯᠠᠭ ᠲᠤᠭᠤᠯᠠᠭ

ᠬᠡᠭᠢᠨ ᠲᠤᠭᠤᠯᠠᠭ ᠲᠤᠭᠤᠯᠠᠭ
ᠲᠤᠭᠤᠯᠠᠭ ᠲᠤᠭᠤᠯᠠᠭ ᠲᠤᠭᠤᠯᠠᠭ
ᠲᠤᠭᠤᠯᠠᠭ ᠲᠤᠭᠤᠯᠠᠭ ᠲᠤᠭᠤᠯᠠᠭ
ᠲᠤᠭᠤᠯᠠᠭ ᠲᠤᠭᠤᠯᠠᠭ ᠲᠤᠭᠤᠯᠠᠭ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ
ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2024 оны 06 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар
хот

**Монгол Улсын Их Хурлын хяналт
шалгалтын тухай хууль, Монгол Улсын Үндсэн
хуулийн цэцийн тухай хууль, Монгол Улсын Их
Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль,
Авлигын эсрэг хуулийн холбогдох зохицуулалт
Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх
маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны
танхим 16.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Г.Баясгалан даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ж.Эрдэнэбулган /илтгэгч/, Д.Гангабаатар, О.Мөнхсайхан, Э.Энхтуяа, Ц.Цолмон, Б.Болдбаатар, Р.Батрагчаа нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Баяржаргалыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Энэхүү хуралдаанаар Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.2 дахь заалт, 1992 оны 5 дугаар сарын 08-ны өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэг, 2006 оны 7 дугаар сарын 06-ны өдөр баталсан Авлигын эсрэг хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь хэсгийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Дөчин есдүгээр зүйлийн 1, 3, 5, 6, Тавин нэгдүгээр зүйлийн 2, Тавин зургадугаар зүйлийн 2, Жаран дөрөвдүгээр зүйлийн 2, 3, Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн эсэх тухай маргааныг дахин хянаж, эцэслэн шийдвэрлэн, Монгол Улсын Их Хурлын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн “Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 05 дугаар дүгнэлтийн тухай” 78 дугаар тогтоолыг хянан хэлэлцэв.

Нэг. Монгол Улсын иргэн Ж.Батмөнх Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандаж дараах агуулга бүхий мэдээлэл болон нэмэлт шаардлага ирүүлжээ:

“Монгол Улсын төрийн байгуулал нь Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Шүүх гэсэн төрийн эрх мэдлийн институтэд хуваагддаг. Төрийн эрх мэдэл хуваарилах энэхүү зарчмын зорилго нь



төрийн эрх мэдлийг засаглалын салаанд хуваарилж, тэдгээр нь бие биедээ харилцан хяналт тавих, тэнцвэрт байдлыг хангахад оршино. Нөгөөтээгүүр Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхийг хязгаарлаж, халдаж болохгүй. Гэтэл Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг батлахдаа Ерөнхийлөгчийн бүрэн эрх болон шүүх эрх мэдлийн бие даасан, хараат бус байдалд халдсан. Тодруулбал, уг хуулийн 29 дүгээр зүйлийн холбогдох заалтад Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, Шүүхийн сахилгын хорооны гишүүнийг томилох, Улсын дээд шүүхийн шүүгчтэй танилцахдаа нэр дэвшигчийн сонголт хийхээр заасан байгаа нь төрийн эрх мэдлийн хяналт харилцан тэнцвэрээ алдах, нэг талын бүрэн эрхэд халдаж, нөлөөлөхөөр байна.

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 5 дахь хэсэгт Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгчид дотроосоо сонгосон болон нээлттэй нэр дэвшсэн гишүүдийг Монгол Улсын Их Хурал томилохоор заасан. Гэтэл нэр дэвшигчийн сонголт хийж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах Шүүхийн ерөнхий зөвлөлийн зорилгод үл нийцсэн, нөлөөлөхүйц оролдлого юм. Мөн Шүүхийн сахилгын хорооны шүүгчид дотроосоо сонгосон болон нээлттэй нэр дэвшсэн гишүүдийг томилохдоо нээлттэй сонголт хийж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасан хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын шийтгэл ногдуулах Шүүхийн сахилгын хорооны бүрэн эрхэд халдсан, нөлөөлж болохуйц үйлдэл юм.

Иймд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад "... Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүн, Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүн, ..." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1, 3, 5, 6, Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Үндсэн хуулийн цэцийн гишүүний гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүх санал болгосноор Улсын Их Хурал томилно. Гэтэл Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Улсын дээд шүүхийн санал болгож байгаа хүмүүст нэр дэвшигчийн сонголт хийж байгаа нь Улсын Их Хурал, Ерөнхийлөгч болон Улсын дээд шүүхийн нэр дэвшүүлэх бүрэн эрхэд шууд халдсан үйлдэл юм. Учир нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн гагцхүү Үндсэн хуульд захирагдаж, аливаа байгууллага, албан тушаалтнаас хараат бус байхаар зохицуулсан. Тиймээс нэр

дэвшигчийн сонсгол хийх нэрийдлээр Үндсэн хуулийн цэцийн хараат бус байдалд нөлөөлөх боломж байсаар байна.

Угтаа бол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Улсын дээд шүүх нь тодорхой шалгуур, үндэслэлээр сонгон авч санал болгож байгаа тул Монгол Улсын Их Хурал томилох эсэхийг шийдвэрлэх ёстой. Мөн хуулийн дээрх зохицуулалттай холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... нэр дэвшигчийн сонсгол хийж ...” гэж оруулсан нэмэлт болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт “... энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулна. ... нэр дэвшигчийн сонсголын тайлан гарснаас хойш ... тухайн тайлан, эрх бүхий этгээдийн ... Санал, дүгнэлтэд сонсголын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр тусгана.” гэсэн өөрчлөлт оруулсан байгаа нь дээрх байдлаар Үндсэн хуулиар тогтоосон эрх бүхий этгээдийн бүрэн эрхийг зөрчсөн байна.

3. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Монгол Улсын Их Хуралд танилцуулах болохоос биш нэр дэвшигчийн сонсгол хийх талаар заагаагүй. Гэтэл Монгол Улсын Их Хурал бас л нэр дэвшигчийн сонсгол хийх нэрийдлээр танилцуулсан хүмүүсийг буцаах оролдлого хийх боломжтой болоод байна.

Дээрхээс дүгнэвэл Монгол Улсын Их Хурал нь шүүх эрх мэдлийн байгууллага, түүний гишүүдийг санал болгосон байгууллагын бүрэн эрхэд халдаж, сонсгол хийх зохицуулалтыг “зөвшөөрөл” гэсэн агуулгаар харж, өөрөөсөө хараат байлгах, дангаар ноёрхох гэсэн зорилго бүхий хууль баталсан гэж үзэж байна. Ингэснээр шүүх эрх мэдэл нь хууль тогтоох эрх мэдлийн хууль бус ажиллагааг хянах бус хянуулах эрсдэл үүссэн байна.

Үүнээс үзэхэд Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад “Үндсэн хуулийн цэцийн гишүүн, ...”, 29.1.2 дахь заалтад “... эсхүл Улсын Их Хурал танилцах, зөвшилцөх, томилохоор хуульд заасан албан тушаалтны хувьд танилцах, зөвшилцөх, томилгооны сонсгол явуулахаар Улсын Их Хурлын есөөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол.” гэж заасан нь, түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... нэр дэвшигчийн сонсгол хийж ...”, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн “... энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулна. ... нэр дэвшигчийн сонсголын тайлан гарснаас хойш ... тухайн тайлан, ... Санал, дүгнэлтэд сонсголын тайлангийн агуулгыг



өөрчлөхгүйгээр тусгана.” гэж тус тус хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1, 3, 5, 6, Тавин нэгдүгээр зүйлийн 2, Жаран дөрөвдүгээр зүйлийн 2, 3, Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчжээ.

4.Мөн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад “... Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга, ...” гэж зааж үүнтэй уялдуулан Авлигын эсрэг хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт “... томилгооны сонгол хийж ...”, мөн зүйлийн 21.2 дахь хэсэгт “... томилгооны сонгол хийж ...” гэж хуульчилжээ. Ийнхүү нэр дэвшигчийн сонгол явуулахаар зохицуулсан нь Авлигатай тэмцэх газрын нэгдмэл удирдлагыг саармагжуулах, бие даасан, хараат бус байх зарчимд нь гаднын хэн нэгэн иргэн болон албан тушаалтны зүгээс нөлөөлөх боломжийг олгох, улмаар үүрэг чиглэл өгөх, амлалт авхуулах зэргээр томилогдсон нөхцөлд цаашид хуулийн дагуу хэвийн үйл ажиллагаагаа ханган ажиллахад сөрөг нөлөө үзүүлэх оролдлого хийх боломжтой байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэснийг зөрчсөн байна. Иймд дээрх шаардлагад дурдсан зохицуулалтуудыг түдгэлзүүлж өгнө үү.” гэжээ.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд ирүүлсэн тайлбартаа:

“1.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүний томилгооны сонголын тухайд, Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.”, Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална.” гэж, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын үндсэн зорилт ард түмний төлөөллийн дээд байгууллагын хувьд ард түмний засаглах эрхийг хангахад оршино.” гэж заасан. Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалтад “хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах;” гэж заасны дагуу Улсын Их Хурлын хянан шалгах бүрэн эрхийг хэрэгжүүлэх тогтолцоо, зорилго, зарчим, арга хэлбэрийг хуульчилж Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг баталсан.

Уг хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хууль, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг биелүүлэх үйл ажиллагаанд тавих Монгол

Улсын Их Хурлын хяналт шалгалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах бөгөөд энэ хуулийн 29 дүгээр зүйлээр эрх бүхий этгээдээс хуульд заасны дагуу санал болгосон нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлаас “Нэр дэвшигчийн сонсгол” явуулах харилцааг зохицуулдаг. Эдгээр нэр дэвшигчдэд Үндсэн хуулийн цэцийн гишүүн болон хуульд заасан бусад этгээд хамаардаг бөгөөд сонсголыг зохион байгуулахдаа Улсын Их Хурлын есөөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан тохиолдолд нэр дэвшигчийн сонсгол явуулахаар хуульд тусгайлан заасан, эсхүл Улсын Их Хурал танилцах, зөвшилцөх, томилохоор хуульд заасан албан тушаалтны хувьд танилцах, зөвшилцөх, томилгооны сонсгол явуулахаар тогтоож өгсөн. Өөрөөр хэлбэл, Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилохдоо хуульд заасны дагуу томилгооны сонсголыг явуулахаар хуульчилсан.

Улсын Их Хурал хяналт шалгалтын бүрэн эрхээ хэрэгжүүлэх хүрээнд дээрх томилгооны сонсголыг зохион байгуулахын гол ач холбогдлыг хууль тогтоогч үзэхдээ нэр дэвшигч этгээд тухайн албан тушаалд тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, мэдлэг, ур чадвар, ёс зүй, хуулиар тусгайлан заасан шаардлагыг хангаж буй эсэхийг олон нийтийн өмнө нээлттэй хэлэлцэж, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, бусад баримт мэдээлэлтэй бүрэн дүүрэн танилцаж, сонсголын үеэр нэр дэвшигчээс асуулт асууж, хариулт авч хэлэлцсэнээр шийдвэр гаргахад бодитой үр дүнтэй гэж үзсэн. Нөгөө талаар нэгэнт хуулиар нээлттэй сонсгол явуулах зарчмаар томилгоо хийх нөхцөл бүрдсэн тохиолдолд нэр дэвшигчийн шаардлага хангаагүй, урьд өмнө эрхэлж байсан ажил мэргэжил, мэргэшлээрээ салбар, байгууллага, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөөгүй, ёс зүйн доголдолтой этгээд нэрээ дэвшүүлэх эрсдэл байхгүй болно.

Парламентын нээлттэй сонсгол бол Улсын Их Хурал хяналт шалгалтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд онцгой ач холбогдолтой, олон нийтийн оролцоотой механизм бөгөөд мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргахдаа ашиглахаас гадна нэр дэвшигчийн талаарх олон нийтийн санаа бодол, тухайн нэр дэвшигчийг дэмжиж байгаа эсэхийг харгахад гол хэрэглүүр болгодог.

Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд томилгооны сонсгол зохион байгуулахаар хуульчилснаар парламент Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох бүрэн эрхээ хэвээр хадгалахын зэрэгцээ нээлттэй сонсголоор дамжуулан ард түмний засаглах эрхийг хэрэгжүүлж, ардчиллын легитим шинжийг хангах давуу нөхцөл байдал бий болсон.

2.Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүний нэр дэвшигчийн сонсголын тухайд, Монгол Улсын

Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 5, 6 дахь хэсэгт зааснаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд тавих шаардлага, хэрхэн томилох журмыг хуулиар тогтоохоор заасан. Тодруулбал, Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг шүүхээс бусад институтийн тэнцвэртэй оролцоог хангаж нээлттэй нэр дэвшүүлэн сонгон шалгаруулж, томилох талаар үндэслэл бүхий бодлогын хувилбаруудаас сонголт хийж хуульчлах нь Монгол Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал юм.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэх ажиллагаа нээлттэй, ил тод байж, олон нийтийн төлөөллийн байгууллагын оролцоог хангаснаар сонгон шалгаруулалт болон томилгоонд аливаа зүй бус нөлөөллийг хаана гэж хууль тогтоогч үзсэн бөгөөд энэ агуулгын хүрээнд эрх бүхий этгээдээс хуульд заасны дагуу санал болгосон нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлын есөөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан тохиолдолд тухайн нэр дэвшигчийн талаар танилцах, зөвшилцөх, томилгооны сонсгол явуулахаар Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд тусгасан. Өөрөөр хэлбэл, Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшсэн иргэнийг Монгол Улсын Их Хурал шууд томилохгүй буюу Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан Ажлын хэсэг хамгийн сайн шаардлага хангасан хүнийг олон нийтэд нээлттэй, ил тодоор сонгон шалгаруулж, Улсын Их Хуралд санал болгон нээлттэй сонгон шалгаруулалт зохион байгуулж, мөн цаашлаад Улсын Их Хурлын есөөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан тохиолдолд Улсын Их Хурлын танилцах болон зөвшилцөх нэр дэвшигчийн сонсгол явуулах юм. Ингэснээр Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцнэ гэж хууль тогтоогч үзсэн.

Нөгөөтээгүүр Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүдийг Улсын Их Хурал томилох нь асуудлыг үзэмжээрээ шийднэ гэсэн үг биш бөгөөд Улсын Их Хурлын дур зоргыг хязгаарласан зохицуулалтыг олон улсын сайн туршлагад үндэслэн Монгол Улсын шүүхийн тухай хуульд хуульчилсан. Тодруулбал, Шүүхийн ерөнхий зөвлөлийг бүрдүүлэх болон хуульчдаас шүүгчийг шилж олох, сонгон шалгаруулж шүүгчээр томилуулах санал гаргах процессыг бүхэлд нь харвал аль нэг институт зүй бусаар илүү эрхтэй оролцох эрсдэлийг бууруулж, институтүүдийг тэнцвэртэй оролцох нөхцөлийг бүрдүүлсэн.

Иймд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтын “Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүн, Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүн ...”, мөн зүйлийн 29.1.2 дахь заалтын “... эсхүл Улсын Их Хурал ... танилцах, зөвшилцөх, ... сонсгол явуулахаар Улсын

Их Хурлын есөөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол.” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1, 3, 5, 6, Тавин нэгдүгээр зүйлийн 2, Жаран дөрөвдүгээр зүйлийн 2, 3, Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчөөгүй гэж үзэж байна.

3.Мэдээллийн нэмэлт шаардлагын тухайд, хууль тогтоогч энэхүү нээлттэй сонсголыг зохион байгуулахдаа баримтлах дэгийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиас гадна Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн зохицуулалтаар тодорхойлсон. ...

4.Монгол Улсын Их Хурал 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, тус байгууллагын даргыг Монгол Улсын Ерөнхий сайдын санал болгосноор, дэд даргыг Авлигатай тэмцэх газрын даргын санал болгосноор томилгооны сонсголд оролцуулж, томилдог шинэ жишгийг тогтоосон. Ийнхүү Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос 2021 оны 7 дугаар сарын 07-ны өдөр Авлигатай тэмцэх газрын дэд даргыг томилохдоо нэр дэвшигчийн томилгооны сонсгол зохион байгуулж энэхүү нээлттэй сонсгол нь иргэд, олон нийтийн оролцоог хангах, нээлттэй ил тод сонсгол байхын чухал ач холбогдлыг нотолсон билээ.

Улсын Их Хурлаас томилогддог албан тушаалтнуудыг томилохдоо сонсгол хийхгүйгээр томилдог байсан өмнөх практикт тухайн нэр дэвшигчийг нэр дэвшүүлсэн бол заавал томилогддог байсан буруу жишгийг халсан. Өөрөөр хэлбэл, тухайн нэр дэвшигч нь хуульд заасан болзол, шалгуурыг хангаж байгаа эсэх, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадвар, эрхэлж байсан ажил, албан тушаал, гэмт хэрэгт холбогдож байсан эсэх зэрэг мэдээлэлтэй огт танилцахгүйгээр томилогддог байсныг халсан явдал юм.

Иймд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн “... энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулна. ... нэр дэвшигчийн сонсголын тайлан гарснаас хойш ... тухайн тайлан, эрх бүхий этгээдийн ... Санал, дүгнэлтэд сонсголын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр тусгана.” гэсэн нь, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн 29.1.1, 29.1.2 дахь заалтын “... Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга ...” гэсэн нь, мөн Авлигын эсрэг хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “... томилгооны сонсгол хийж ...” гэсэн нь тус тус Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй гэж үзэж энэхүү тайлбарыг хүргүүлж байна.” гэжээ.

Гурав. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц дээрх маргааныг 2023 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр Дунд суудлын хуралдаанаар хянан хэлэлцэж, 05 дугаар дүгнэлтийг гаргасан болно. Уг дүгнэлтийн үндэслэл хэсэгт:

“1.Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн тавыг шүүгчид дотроосоо сонгож, бусад таван гишүүнийг нээлттэйгээр нэр дэвшүүлж томилно. ... Зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно.”, мөн зүйлийн 6 дахь хэсэгт “Хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл ногдуулах чиг үүрэг бүхий Шүүхийн сахилгын хороо ажиллах бөгөөд түүний бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно.” гэж заасан.

Энэхүү зохицуулалтын дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1-77.11 дэх хэсэгт Улсын Их Хурал Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг тодорхой журмаар нээлттэйгээр нэр дэвшүүлж, томилгооны сонсгол явуулахаар заасан байх бөгөөд мөн хуулийн 95 дугаар зүйлийн 95.4 дэх хэсэгт “Сахилгын хорооны бүрэлдэхүүнд хяналтын шатны шүүхээс нэг, давж заалдах шатны шүүхээс хоёр, анхан шатны шүүхээс нэг шүүгчийг Нийт шүүгчийн чуулганаас нууц санал хураалтаар сонгож, Сахилгын хорооны бүрэлдэхүүнд орох бусад таван гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал томилно. ...” гэж тусгайлан зааж, Сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг тус хуулийн 77 дугаар зүйлийн холбогдох заалтад зааснаар нээлттэй нэр дэвшүүлж томилгооны сонсгол явуулан томилохоор хуульчилжээ.

Ийнхүү Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн холбогдох зохицуулалтаар Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийн томилгооны сонсгол хийхээр хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн дээр дурдсан зохицуулалтын дагуу нэр дэвшүүлж томилох ажиллагаа нь нээлттэй байх үзэл баримтлалд нийцсэн байх бөгөөд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн зохицуулалттай уялдаатай байх тул Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулаагүй байна.

2.Авлигын эсрэг хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт Авлигатай тэмцэх газрыг авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, энэ хуульд заасан этгээдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан, төрийн тусгай байгууллага гэж тодорхойлжээ.

Мөн тухайн байгууллагын бүтэц, орон тоог батлах; түүнчлэн өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийг үндэслэн шийдвэрлэх; Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргыг холбогдох журмын дагуу томилох, чөлөөлөх, огцруулах бүрэн эрхийг Улсын Их Хурал хэрэгжүүлэхээр уг хуулийн 15, 17, 21, 22 дугаар зүйлд тус тус хуульчилсан байна.

Үүнээс үзэхэд төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэгч тухайн байгууллагын холбогдох албан тушаалтанд тавигдах шалгуур, болзлыг нарийвчлан тодорхойлж, нэр дэвшүүлэн томилох журмыг хуульчлан тогтоох нь хууль тогтоогчийн бүрэн эрхэд хамаарч байна. Иймд Авлигын эсрэг хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь хэсэгт "... томилгооны сонсгол хийж ..." гэж тус тус заасан нь, түүнчлэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад "... Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга, ..." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулаагүй байна.

3.Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.", мөн зүйлийн 3 дахь хэсэгт "Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана.", Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно." гэж заасан.

Мөн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.", Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар ... Ерөнхийлөгч томилно. Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор гишүүдийнх нь дотроос зургаан жилийн хугацаагаар Ерөнхийлөгч томилно." гэж тус тус тогтоожээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн эдгээр зохицуулалт нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч дээд байгууллагуудын бие даасан, хараат бус байдлын баталгааг бүрдүүлсэн байх бөгөөд Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлэгч болон шүүх эрх мэдлийн холбогдох албан тушаалд нэр дэвшүүлэх, томилох байгууллага, албан тушаалтныг Үндсэн хуулийн түвшинд тодорхойлон хуульчилсан гэж үзэхээр байна.

4.Ийнхүү Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэн санал болгох онцгой бүрэн эрхийг Үндсэн хуулиар тодорхойлж Монгол Улсын

Ерөнхийлөгч, Улсын дээд шүүх зэрэг эрх бүхий этгээдэд олгосон байхад ердийн хуулиар буюу Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад Үндсэн хуулийн цэцийн гишүүнд томилуулахаар санал болгосон нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлаас томилгооны сонсгол хийхээр зохицуулсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн дээр дурдсан заалтад заасан бүрэн эрхийг хөндөж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн болон тухайн институтийн бие даасан, хараат бус байдлын баталгааг алдагдуулах үндэслэлтэй байна.

Тодруулбал, Үндсэн хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын дээд шүүх болон холбогдох эрх бүхий этгээд нь нэгэнт сонгон шалгаруулалт хийж нэр дэвшүүлэн санал болгож байхад дээрх зохицуулалтаар тухайн бүрэн эрхэд нь хөндлөнгөөс нөлөөлөх, шууд бусаар халдах боломжийг олгосон нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2, 3, Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн байна.

5.Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг /мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалт/ баталсантай уялдуулж Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт нэр дэвшигчийн сонсгол хийхтэй холбоотой нэмэлт, өөрчлөлт оруулсан нь дээр дурдсан үндэслэлээр Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

6.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтад танилцах, зөвшилцөх, томилохоор хуульд заасан албан тушаалтны хувьд Улсын Их Хурлын есөөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол явуулахаар заасан нь агуулгын хувьд Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар ... Ерөнхийлөгч томилно. ...” гэсэн заалтад нийцэхгүй байна.

Тухайлбал, уг зохицуулалтын дагуу тодорхой тооны Улсын Их Хурлын гишүүний саналаар Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчид холбогдуулан сонсгол хийж болох эрх зүйн үр дагаврыг үүсгэж байгаа нь Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг сонгон шалгаруулж танилцуулах эрх бүхий этгээд болон улмаар тэднийг томилох Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үндсэн хуулиар тодорхойлсон бүрэн эрхийг хязгаарлаж хөндлөнгөөс шууд бусаар нөлөөлөх боломжийг бүрдүүлсэн гэж үзэхээр байна.

Мөн дээрх зохицуулалтад “зөвшилцөх” гэж тусгасан нь Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нарыг Улсын Их Хуралтай зөвшилцөн Ерөнхийлөгч томилох талаарх Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтад харшилж байна.

7.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн заалтууд нь нийтлэг агуулгатай буюу анх болон дахин томилогдож байгаа аль ч нэр дэвшигчид хамаарах ерөнхий утгыг илэрхийлсэн зохицуулалт байна.

Энэ нь маргаан бүхий зохицуулалтын хүрээнд авч үзвэл эрх бүхий этгээд Үндсэн хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд холбогдох албан тушаалд өмнө томилогдсон хүнийг дахин нэр дэвшүүлэн санал болгох тохиолдолд дахин томилгооны сонсгол хийх үр дагаврыг үүсгэж байх бөгөөд улмаар тухайн албан тушаалтны өмнөх бүрэн эрхийн хугацаанд гаргасан шийдвэр, үйл ажиллагаа /хамтын зарчмаар гаргасан эсэхээс үл хамааран/-г шүүн хэлэлцэх, үнэлэлт дүгнэлт хийх боломжийг бүрдүүлж, хуулиар баталгаажсан хараат бус байдлын зарчмыг алдагдуулах нөхцөлийг үүсгэсэн гэж үзэхээр байна.

Иймд дээрх зохицуулалтыг боловсронгуй болгож тухайн албан тушаалын онцлогтой холбогдуулан анх болон дахин томилогдохтой холбоотой зохицуулалтыг нарийвчлан хуульчлах шаардлагатайг тэмдэглэх нь зүйтэй.” гэсэн байна.

Дүгнэлтийн тогтоох хэсэгт:

“1.Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад “Үндсэн хуулийн цэцийн гишүүн, ...”, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... нэр дэвшигчийн сонсгол хийж ...”, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт “... энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулна. ... нэр дэвшигчийн сонсголын тайлан гарснаас хойш ... тухайн тайлан, ... Санал, дүгнэлтэд сонсголын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр тусгана.” гэж тус тус заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.”, 3 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана.”, Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг

Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.” гэснийг тус тус зөрчсөн байна.

2.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтад “... эсхүл Улсын Их Хурал танилцах, зөвшилцөх, томилохоор хуульд заасан албан тушаалтны хувьд танилцах, зөвшилцөх, томилгооны сонгол явуулахаар Улсын Их Хурлын есөөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол.” гэж заасны “... танилцах, зөвшилцөх, ... танилцах, зөвшилцөх, ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.”, Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар ... Ерөнхийлөгч томилно. ...”, Тавин зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нарыг Улсын Их Хуралтай зөвшилцөн Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар томилно.” гэснийг тус тус зөрчсөн байна.

3.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад “... Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүн, Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүн, ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1, 3, 5, 6, Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийг тус тус зөрчөөгүй байна.

4.Авлигын эсрэг хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь хэсэгт “... томилгооны сонгол хийж ...” гэж тус тус заасан нь, түүнчлэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад “... Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн холбогдох заалтыг зөрчөөгүй байна.

5.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад “Үндсэн хуулийн цэцийн гишүүн, ...”, 29.1.2 дахь заалтад “... танилцах, зөвшилцөх, ... танилцах, зөвшилцөх, ...” гэж, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... нэр дэвшигчийн сонгол хийж ...” гэж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт “... энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонгол зохион байгуулна. ... нэр дэвшигчийн сонголын тайлан гарснаас хойш ... тухайн тайлан, ... Санал, дүгнэлтэд сонсголын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр тусгана.” гэж тус тус заасныг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2023 оны 9 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй. ...” гэсэн болно.

Дөрөв. Үндсэн хуулийн цэцийн дээрх дүгнэлтийг Улсын Их Хурал 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд 78 дугаар тогтоолыг гаргасан байна. Үүнд:

“1.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад “Үндсэн хуулийн цэцийн гишүүн, ...”, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... нэр дэвшигчийн сонсгол хийж ...”, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт “... энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулна. ... нэр дэвшигчийн сонсголын тайлан гарснаас хойш ... тухайн тайлан, ... Санал, дүгнэлтэд сонсголын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр тусгана.” гэж тус тус заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.”, 3 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана.”, Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.” гэж заасныг тус тус зөрчсөн байна.” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 05 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтад “... эсхүл Улсын Их Хурал танилцах, зөвшилцөх, томилохоор хуульд заасан албан тушаалтны хувьд танилцах, зөвшилцөх, томилгооны сонсгол явуулахаар Улсын Их Хурлын есөөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол.” гэж заасны “... танилцах, зөвшилцөх, ... танилцах, зөвшилцөх, ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.”, Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар ... Ерөнхийлөгч томилно. ...”, Тавин зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нарыг Улсын Их Хуралтай зөвшилцөн Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар томилно.” гэж заасныг тус тус зөрчсөн байна.” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 05 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.” гэжээ.

Тав. Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд ирүүлсэн тайлбартаа:

“1.Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшигчийн талаарх томилгооны сонсгол

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшигчийн талаарх томилгооны сонсгол явуулахаар хуульчлан заасан. Гэвч Үндсэн хуулийн цэц 2023 оны 05 дугаар дүгнэлтдээ уг заалтын “Үндсэн хуулийн цэцийн гишүүн” гэж заасан нь Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэг, Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчсөн гэж үзжээ. Уг дүгнэлтийг дараах үндэслэлээр хүлээн зөвшөөрөх боломжгүй байна.

1.1.Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.”, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана.” гэж тус тус заасан нь Үндсэн хуулийн цэцийг төрийн байгууллага, институт болохын хувьд хараат бус байх зарчмыг илэрхийлсэн гэж үзэх үндэслэлтэй бөгөөд энэ нь Үндсэн хууль, Монгол Үндсэн хуулийн цэцийн тухай хууль зэрэг холбогдох бусад хуулиудаар түүний эрх зүй, зохион байгуулалт, эдийн засгийн хараат бус байдлыг хуульчилсан баталгаанаас бүрддэг билээ. Мөн уг заалтаар Үндсэн хуулийн цэцийн гишүүн үүргээ гүйцэтгэхдээ албан тушаалтан, аливаа этгээдээс хараат бус байх зарчмыг хуульчилжээ. Үндсэн хуулийн дээрх заалт нь Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр нэгэнт томилогдсоны дараа тухайн албан тушаалтны хараат бус байдлыг хамгаалах агуулгатай болохоос бус уг албан тушаалд нэр дэвшиж буй этгээдэд хамаарахгүй юм. Мөн Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 05 дугаар дүгнэлтэд нэр дэвшигчийн сонсгол явуулах нь “тухайн институтын бие даасан, хараат бус байдлын баталгааг алдагдуулах үндэслэлтэй” гэж дүгнэсэн боловч Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр нэр дэвшигчийг томилох ажиллагаа, уг байгууллагын хараат бус байдлын баталгаа хоорондын харилцан хамаарлыг үндэслэлтэй гаргаагүй байна.

1.2.Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.” гэж Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох харилцааг Үндсэн хуулийн түвшинд зохицуулжээ.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.2 дахь заалтад томилгооны сонсгол хийхээр зохицуулсныг Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 05 дугаар дүгнэлтэд “Үндсэн хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын дээд шүүх болон холбогдох эрх бүхий этгээд нь нэгэнт сонгон шалгаруулалт хийж нэр дэвшүүлэн санал болгож байхад дээрх зохицуулалтаар тухайн бүрэн эрхэд нь хөндлөнгөөс нөлөөлөх, шууд бусаар халдах боломжийг олгосон нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн” гэж дурджээ. Гэвч хуулиар томилгооны сонсгол хийхээр заасан нь Ерөнхийлөгч, Улсын дээд шүүхийн Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшигчийг санал болгох бүрэн эрхэд халдсан үр дагавар үүсгэхгүй юм. Өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Улсын Их Хурал дээрх хоёр институтын санал болгосон нэр дэвшигчийг хэлэлцэж, томилох, эсхүл томилохгүй байх шийдвэрийн аль нэгийг гаргадаг. Үндсэн хуулийн зохицуулалтаас үзэхэд томилох эсэх эцсийн шийдвэр гаргах эрх Улсын Их Хуралд хадгалагдах юм. Мөн сонсгол явуулах ажиллагаа нь нэр дэвшигчийг санал болгох ажиллагааны дараа хийгдэх ажиллагаа тул түүнд нөлөөлөх боломжгүй юм.

1.3.Онцлон тэмдэглэхэд, парламентын нээлттэй сонсгол бол Улсын Их Хурал хяналт шалгалтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд өндөр ач холбогдолтой, олон нийтийн оролцоотой механизм бөгөөд мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргахдаа түүнийг ашиглахаас гадна нэр дэвшигчийн талаарх олон нийтийн санаа бодлыг тандан судлах гол хэрэглүүр болдог.

Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэх хүрээнд дээрх томилгооны сонсголыг зохион байгуулахын гол ач холбогдлыг хууль тогтоогч үзэхдээ нэр дэвшигч этгээд тухайн албан тушаалд тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, мэдлэг, ур чадвар, ёс зүй, хуулиар тусгайлан заасан шаардлагыг хангаж буй эсэхийг олон нийтийн өмнө нээлттэй хэлэлцэж, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, бусад баримт мэдээлэлтэй бүрэн дүүрэн танилцаж, сонсголын үеэр нэр дэвшигчээс асуулт асууж, хариулт авч хэлэлцсэнээр шийдвэр гаргахад бодит үр нөлөө үзүүлнэ гэж үзсэн байна.

1.4.Үндсэн хуулийн цэцийн холбогдох дүгнэлтэд “Монгол Улсын Үндсэн хуулийн эдгээр зохицуулалт нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч дээд байгууллагуудын бие даасан, хараат бус байдлын баталгааг бүрдүүлсэн байх бөгөөд Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлэгч болон шүүх эрх мэдлийн холбогдох албан тушаалд нэр дэвшүүлэх, томилох байгууллага, албан тушаалтныг Үндсэн хуулийн түвшинд тодорхойлон хуульчилсан гэж үзэхээр байна” гэж дүгнэжээ.

Гэвч Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг Улсын Их Хурлаас томилох, Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг Улсын Их Хуралд танилцуулах процессыг зөвхөн Үндсэн хуулиар зохицуулна гэж үзэх үндэслэлгүй юм. Тухайлбал, Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” гэж заасны дагуу Улсын Их Хурлын бүрэн эрх, үйл ажиллагааны журмыг тогтоосон холбогдох хуулиудаар албан тушаалтныг томилох, танилцах процессурыг хэрхэн тодорхойлох нь Улсын Их Хурлын хууль тогтоох бүрэн эрхэд хадгалагдах бөгөөд энэ хүрээнд нэр дэвшигчийн сонголт зохион байгуулах нь Үндсэн хуулийн үзэл баримтлалд харшлахгүй юм.

2.Улсын Их Хурлаас зохион байгуулах нэр дэвшигчийн танилцах, зөвшилцөх сонголт

Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 05 дугаар дүгнэлтээр Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтад “... эсхүл Улсын Их Хурал танилцах, зөвшилцөх, томилохоор хуульд заасан албан тушаалтны хувьд танилцах, зөвшилцөх, томилгооны сонголт явуулахаар Улсын Их Хурлын есөөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол.” гэж заасны “... танилцах, зөвшилцөх, ... танилцах, зөвшилцөх, ...” гэсэн нь Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1, Тавин нэгдүгээр зүйлийн 2, Тавин зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус зөрчсөн гэж үзсэнийг дараах үндэслэлээр хүлээн зөвшөөрөхгүй байна.

2.1.Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар ... Ерөнхийлөгч томилно.”, Тавин зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нарыг Улсын Их Хуралтай зөвшилцөн Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар томилно.” гэж тус тус заасан. ... Улсын Их Хурлаас шүүгчид нэр дэвшигчтэй танилцах сонголт явуулж байгаа нь танилцах ажиллагааны нэг хэсэг тул энэ нь Шүүхийн ерөнхий зөвлөлөөс нэр дэвшигчийг санал болгох, Ерөнхийлөгч томилох бүрэн эрхэд нөлөөлөхгүй. Энэхүү “танилцах” бүрэн эрхийг Улсын Их Хуралд Үндсэн хуулиар олгожээ. Танилцах ажиллагааны гол зорилго нь шүүх эрх мэдлийн дээд байгууллагад томилогдох гэж буй нэр дэвшигчийн тухайн албан тушаалд тавих шалгуурыг хэрхэн хангаж буйг ард түмний төлөөллийн байгууллагаар дамжуулж иргэд, олон нийтэд мэдээлэх явдал юм. Энэ утгаараа хуулийн маргаан бүхий заалт нь Үндсэн хууль зөрчөөгүй гэж үзэж байна.

2.2.Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.” гэж заасан бөгөөд энэ заалт нь өмнө ... дурдсанчлан нэгэнт томилогдсоны дараа хэрэгжих хараат бус байдлын тухай ойлголт юм.” гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

1.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад “Үндсэн хуулийн цэцийн гишүүн, ...”, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... нэр дэвшигчийн сонсгол хийж ...”, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт “... энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулна. ... нэр дэвшигчийн сонсголын тайлан гарснаас хойш ... тухайн тайлан, ... Санал, дүгнэлтэд сонсголын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр тусгана.” гэж тус тус заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2, 3, Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийг; Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтад “... эсхүл Улсын Их Хурал танилцах, зөвшилцөх, томилохоор хуульд заасан албан тушаалтны хувьд танилцах, зөвшилцөх, томилгооны сонсгол явуулахаар Улсын Их Хурлын есөөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол.” гэж заасны “... танилцах, зөвшилцөх, ... танилцах, зөвшилцөх, ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1, Тавин нэгдүгээр зүйлийн 2, Тавин зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус зөрчсөн гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 05 дугаар дүгнэлтийн 1, 2 дахь заалт үндэслэлтэй байна.

Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч болон Улсын дээд шүүхээс Үндсэн хуулийн цэцийн гишүүнд, Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Улсын ерөнхий прокурор, түүний орлогчид тус тус санал болгохдоо эдгээр нэр дэвшигчийг хэрхэн шилж олох журмыг холбогдох хуульд нарийвчлан тогтоох боломж нь нээлттэй байна.

2.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад “... Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүн, Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүн, ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1, 3, 5, 6, Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийг; Авлигын эсрэг хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь хэсэгт “... томилгооны сонсгол хийж ...” гэж тус тус заасан нь, түүнчлэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад “... Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн холбогдох заалтыг тус тус зөрчөөгүй гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 05 дугаар дүгнэлтийн 3, 4 дэх заалт үндэслэлтэй байна.

Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокурор, түүний орлогчоос бусад албан тушаалд нэр



дэвшигчийн сонсгол явуулахаар хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлд заасан Улсын Их Хурлын хууль тогтоох онцгой бүрэн эрхэд хамаарах асуудал байна.

3.Дээр дурдсан хуулийн холбогдох зохицуулалтын уялдаа холбоо, тодорхой байдлыг хангах хүрээнд хуулийг боловсронгуй болгох шаардлага байгааг тэмдэглэж байна. Тухайлбал Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокурор, түүний орлогчид нэр дэвшигчийн талаарх мэдээллийн ил тод байдлыг хангах, мэдээлэл олж авах боломжит хугацааг олгох зэрэг нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

4.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй тогтоол гаргасан бол түүний үндэслэлийг Цэц бүрэн бүрэлдэхүүнтэй хуралдаанаар маргааныг эхнээс нь дахин хэлэлцэж, Улсын Их Хурал дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй үндэслэл зөв болох нь нотлогдвол өмнөх дүгнэлтээ хүчингүй болгох, хэрэв үндэслэл нь батлагдахгүй бол Улсын Их Хурлын тогтоолыг хүчингүй болгож тогтоол гаргана.” гэж заасан боловч Монгол Улсын Их Хурлын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн “Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 05 дугаар дүгнэлтийн тухай” 78 дугаар тогтоолд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй үндэслэлээ тусгаагүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл, Жаран зургадугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2, 32 дугаар зүйлийн 2, 36 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийг удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад “Үндсэн хуулийн цэцийн гишүүн, ...”, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... нэр дэвшигчийн сонсгол хийж ...”, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт “... энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулна. ... нэр дэвшигчийн сонсголын тайлан гарснаас хойш ... тухайн тайлан, ... Санал, дүгнэлтэд сонсголын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр тусгана.” гэж тус тус заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.”, 3 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэцийн гишүүний



хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана.”, Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.” гэснийг тус тус зөрчсөн байх тул хүчингүй болгосугай.

2.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтад “... эсхүл Улсын Их Хурал танилцах, зөвшилцөх, томилохоор хуульд заасан албан тушаалтны хувьд танилцах, зөвшилцөх, томилгооны сонсгол явуулахаар Улсын Их Хурлын есөөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол.” гэж заасны “... танилцах, зөвшилцөх, ... танилцах, зөвшилцөх, ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.”, Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар ... Ерөнхийлөгч томилно. ...”, Тавин зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нарыг Улсын Их Хуралтай зөвшилцөн Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар томилно.” гэж заасныг тус тус зөрчсөн байх тул хүчингүй болгосугай.

3.Монгол Улсын Их Хурлын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн “Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 05 дугаар дүгнэлтийн тухай” 78 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэхүү тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ

Г.БАЯСГАЛАН

ГИШҮҮД

Ж.ЭРДЭНЭБУЛГАН

Д.ГАНГАБААТАР

О.МӨНХСАЙХАН

Э.ЭНХТУЯА

Ц.ЦОЛМОН

Б.БОЛДБААТАР

Р.БАТРАГЧАА



Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 4

Индекс: 200003